



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын ээлжит бус чуулган товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.4 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдрөөс 9 дүгээр сарын 18-ны өдрүүдэд зарлан хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай:

1/Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай асуудал;

2/Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг.

2.Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн Даваа гарагийн 09.00 цагт эхлэхээр товлосугай.

3.Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хуралдааныг өглөө 09.00 цагаас эхэлж үдээс хойш 14.00 цагаас үргэлжлүүлсүгэй.

4.Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нар болон Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт даалгасугай.

ДЭД ДАРГА



РИОНЧИГДОРЖ

0000000600